

БАТЛАВ:  
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГА  
Ц.ЧОГСОМЖАВ  
2024 оны 02 дугаар сарын 09-нд

УДИРДАМЖ

2024 оны 02 дугаар сарын 09-нд

№

Чингис хот

ХЭНТИЙ АЙМГИЙН ТӨРИЙН ЗАХИРГААНЫ БОЛОН  
ТӨРИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ БАЙГУУЛЛАГУУДЫН ДУНД  
ЗОХИОН БАЙГУУЛАХ “АСУУДЛААС ШИЙДЭЛД”  
ТЭМЦЭЭНИЙ ТУХАЙ

**Нэг. Нийтлэг үндэслэл**

1.1. Энэхүү удирдамжаар Хэнтий аймгийн төрийн захиргааны болон төрийн үйлчилгээний байгууллагуудын (цаашид “Байгууллагууд” гэх) дунд “Асуудлаас шийдэлд” (цаашид “тэмцээн” гэх) тэмцээний хамрах хүрээ, зохион байгуулалт, шалгаруулалт, шагнаж урамшуулахтай холбогдсон харилцааг зохицуулна.

1.2. Тэмцээний зорилго нь Хэнтий аймгийн төрийн захиргааны болон төрийн үйлчилгээний байгууллагууд авлига, ашиг сонирхлоос ангид байж үндсэн чиг үүргээ хэрэгжүүлэхэд тулгамдаж буй асуудлаа тодорхойлон шийдвэрлэж, алба хаагчдын нийгмийн баталгааг хангахад оршино.

1.3. Тэмцээний шалгаруулалтад ажлын хэсэг дараах зарчим, шалгуурыг баримтална.

1.3.1. Ил тод, нээлттэй, шударга байх;

1.3.2. Тэмцээнд оролцогчдын ажлын үр дүн, оролцоо, манлайлал, сахилга ёс зүйг харгалзах;

**Хоёр. Хамрах хүрээ**

2.1. Тэмцээнд аймгийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж байгаа төрийн захиргааны болон төрийн үйлчилгээний бүх байгууллага, албан хаагчдыг бүрэн хамруулна.

**Гурав. Зохион байгуулалт**

3.1. Тэмцээнийг Хэнтий аймгийн Засаг даргын Тамгын газар, төрийн болон төрийн бус байгууллага, иргэний төлөөллүүд оролцуулсан ажлын хэсэг зохион байгуулах бөгөөд ажлын хэсгийн гишүүдийг аймгийн Засаг даргын захирамжаар томилно. Ажлын хэсгийн гишүүдээр ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ илэрхийлэх баталгаа (Улсын Их Хурлын Хууль зүйн байнгын хорооны 2012 оны 5 дугаар тогтоолын 04 дүгээр хавсралт) гаргуулна.

3.2. Тэмцээн 2 үе шаттайгаар явагдана.

### **3.3. Нэгдүгээр шат:**

2024 оны 03 дугаар сарын 01-ны өдрөөс 2024 оны 5 дугаар сарын 01-ний өдрийг хүртэлх хугацаанд зохион байгуулагдах бөгөөд 2024 оны 5 дугаар сарын 06-ны өдрөөс 2024 оны 5 дугаар сарын 10-ны өдрүүдэд сум, байгууллага тус бүрд ажлын хэсэг очиж нэгдүгээр шатны шалгаруулалтыг зохион байгуулна.

3.3.1. Тэмцээний нэгдүгээр шатанд байгууллагууд асуудал, шийдлээ тодорхойлж, гэрийн даалгавар гүйцэтгэн нийт 100 хүртэл оноо цуглуулна.

3.3.2. Нийт 100 онооны 40 оноо нь асуудал, шийдлээ тодорхойлох, 60 оноо нь гэрийн даалгавар байна.

3.3.3. Тэмцээний эхний шатанд тухайн байгууллагын бүх албан хаагчид өөрийн байгууллагын болон албан тушаалын тодорхойлолтод заасан үндсэн чиг үүргээ хэрэгжүүлэхэд тулгамдаж байгаа нэг асуудлыг шийдлийн хамт (авлига, ашиг, сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх, иргэдэд төрийн үйлчилгээг хүргэхэд гарч байгаа хүндрэл, иргэдийг чирэгдүүлж байгаа шалтгаан нөхцөлийг арилгах, бага зардлаар төрийн үйлчилгээг иргэдэд хүргэх, байгууллагын дотогш чиглэсэн тулгамдаж буй асуудлыг шийдэх, байгууллагын чиг үүргийн хүрээнд шинэ санал санаачлаг гаргах гэх мэт) хавсралт хүснэгт 1-ийн дагуу 2024 оны 3 дугаар сарын 15-ны дотор тодорхойлж дууссан байна.

3.3.4. Байгууллагын хамт олны хуралд бүх албан хаагчид өөрсдийн тодорхойлж бичсэн асуудал, шийдлийг нэг бүрчлэн танилцуулж, хамгийн олон санал авсан нэг асуудал, шийдлийг 2024 оны 3 дугаар сарын 20-ны дотор шалгаруулна.

3.3.5. Шалгарсан асуудлыг практикт шийдэх 5 албан хаагчийн бүрэлдэхүүнтэй багийг байгуулах ба багийн ахлагч нь тухайн байгууллагын дарга өөрөө байна. Байгууллагын баг өөрийн оноосон нэртэй байна.

3.3.6. Баг шалгарсан асуудал шийдлээр танилцуулга /асуудлын суурь түвшин, шийдлээр хүрэх түвшин, гарах зардал зэрэг агуулгыг тусгасан 5 минутад багтсан танилцуулгын бүх хэлбэрийг зөвшөөрнө/ бэлтгэж сум, байгууллага хариуцсан шүүгч рүү 2024 оны 4 дүгээр сарын 15-ны дотор цахимаар илгээнэ.

3.3.7. Байгууллага бүр төрийн албаны тухай хуулийн 53 дугаар зүйлд заасан төрийн албан хаагчийн нийгмийн баталгааг хангах ажлын хүрээнд гэрийн даалгавар гүйцэтгэх ба амьдрах орчин нөхцөлөө сайжруулах хүсэлт гаргасан албан хаагчдын хүсэлтийг хамт олны хурлаар хэлэлцүүлэн, санал хураан, тэмдэглэл хөтөлж, 1 албан хаагчийг сонгож, тухайн албан хаагчийн амьдрах орчин, нөхцөлийг тэмцээний нэгдүгээр шатанд хамт олны үүсгэл санаачлаг, тусlamж дэмжлэгээр сайжруулах

ажлыг 03 дугаар сарын 20-ноос 05 дугаар сарын 01-ны өдөр хүртэлх хугацаанд зохион байгуулна.

3.3.8. Тэмцээний гэрийн даалгаврын хүрээнд хийж гүйцэтгэсэн ажлын танилцуулгыг 1-3 постерт багтаан 2024 оны 05 дугаар сарын 01-ны өдрийн 17 цагийн дотор ТЗУХ-ийн Хэвлэл мэдээллийн албанад ирүүлнэ./утас:91116109/ Постер нь тэмцээний брэндбүүкийн дагуу хийгдсэн байх ба брэндбүүкийг байгууллагууд руу урьдчилан хүргүүлнэ.

3.3.9. Байгууллагуудын гэрийн даалгаврын постер нь “Асуудлаас шийдэл” пэйж хуудсанд 1 хоногийн хугацаатай байрших бөгөөд иргэдийн хандалт /лайк/-ын тоогоор оноо өгнө. /постер байршуулах хуваарийг 2024 оны 04 дүгээр сарын 25-ны өдрийн дотор байгууллагуудад хүргүүлнэ/

3.3.10. Тэмцээний нэгдүгээр шатны гүйцэтгэлийн үнэлгээний онооны дарааллыг үндэслэн 18 сум, 5 тосгон тус бүрээс 1, аймгийн төвийн байгууллагуудаас 20 хүртэл байгууллагыг 2 дугаар шатанд шалгаруулна.

#### **3.4. Хоёрдугаар шат:**

2024 оны 05 дугаар сарын 13-ны өдрөөс 2024 оны 09 дүгээр сарын 01-ны өдөр хүртэл зохион байгууллагдах бөгөөд шалгаруулалтыг 2024 оны 09 дүгээр сард Чингис хотод нэгдсэн журмаар зохион байгуулна.

3.4.1. Тэмцээний хоёрдугаар шатанд байгууллагууд тодорхойлсон асуудлын шийдлийг үйл ажиллагаанд аа буюу практикт туршин хэрэгжүүлж ач холбогдол үр дүнг тооцуулж 100 хүртэл оноо цуглувулна.

3.4.2. Байгууллагын баг ажлын даалгаврын гүйцэтгэлийн танилцуулгыг бэлтгэж, нотломжийн хамт сум, байгууллага хариуцсан шүүгч рүү 2024 оны 09 дүгээр сарын 02-ны дотор цахимаар ирүүлнэ.

3.4.3. Ажлын хэсэг шаардлагатай бол хоёрдугаар шатны гүйцэтгэл, үр дүнг газар дээр нь очиж танилцаж болно.

3.4.4. Ажлын хэсэг шалгаруулалтыг 09 дүгээр сард багтаан Чингис хотод зохион байгуулах бөгөөд практикт шийдсэн асуудлын танилцуулгыг багийн нэг гишүүн 8 минутад багтааж ямарч хэлбэрээр танилцуулж болно.

#### **Дөрөв. Шалгаруулалт**

4.1. Тэмцээний нэгдүгээр шатанд байгууллагууд тулгамдаж буй асуудлаа тодорхойлон гарц, шийдлийг практикт эрэлхийлснийг дараах байдлаар дүгнэнэ.

4.1.1. Тухайн байгууллагын албан хаагч тус бүр тулгамдаж буй асуудал, шийдлээ тодорхойлон, хамт олны хуралдаанаар нэг бүрчлэн танилцуулж нэг асуудал, шийдэл шалгаруулсан талаарх бичмэл тайлан, фото зургаар

баталгаажуулж албан хаагч тус бүрийн хүснэгтийг хавсаргасан байдал 10 хүртэл оноо

4.1.2. Удирдамжийн 4.1.1 дахь хэсэгт заасан үйл ажиллагааг зохион байгуулсан талаарх мэдээллийг байгууллагын цахим хуудсанд байршуулан олон нийтэд хүргэсэн болон шалгарсан нэг асуудлыг шийдэх 5 албан хаагчтай баг байгуулж, танилцуулгыг бэлтгэж хариуцсан шүүгчид хугацаанд нь ирүүлсэн байдал 10 хүртэл оноо

4.1.3. Сум, байгууллагад ажиллах ажлын хэсэгт тухайн байгууллагын баг нэгдүгээр шатны даалгавруудыг хэрхэн гүйцэтгэсэн тухай болон тулгамдсан асуудлаа хоёрдугаар шатанд хэрхэн гүйцэтгэх “Асуудлаас-Шийдэлд” сэдэвт танилцуулгад 10 хүртэл оноо

4.1.4. Байгууллагуудын гэрийн даалгаврын постер нь “Асуудлаас шийдэлд” пэйж хуудсанд 1 хоногийн хугацаатай байрших бөгөөд иргэдийн хандалт /лайк/-ын тоогоор 10 хүртэлх оноо

4.1.5. Гэрийн даалгаварт 60 хүртэл оноо

**Зөвлөмж:** Байгууллага нийгмийн баталгааны хүрээнд нэг албан хаагчийг хэрхэн сонгосон /хүсэлт гаргасан албан хаагчдын хүсэлтийг хамт олны хурлаар хэлэлцүүлж, санал хураалт явуулсан эсэх, хурлын тэмдэглэл хөтөлсөн байдал/ тухайн албан хаагчийн амьдрах орчин, нөхцөлийг хамт олны үүсгэл санаачлаг, тусlamж дэмжлэгээр хэрхэн амьдрах орчин сайжруулсан, сайн үйлсийн ажилд хамт олныг бүрэн хамруулан зохион байгуулсныг харгалзана.

4.2. Хоёрдугаар шатанд шалгарсан байгууллагууд 05 сарын 01-ээс 2024 оны 09 дүгээр сарын 01- ний өдөр хүртэлх хугацаанд тодорхойлж гаргасан асуудал шийдлийг практикт туршин хэрэгжүүлсэн ач холбогдол үр дүнг дараах байдлаар үнэлж дүгнэнэ. Үүнд:

1. Зорилт, арга хэмжээ нь оновчтой тодорхойлогдсон, шалгуур үзүүлэлт, зорилтот түвшиндээ бүрэн хүрсэн, удирдлага зохион байгуулалт сайн, үр дүн гарсан бол 100 хувь;

2. Зорилт нь шалгуур үзүүлэлт, зорилтот түвшиндээ бүрэн хүрээгүй, тодорхой үр дүн гарч эхэлж байгаа, хэрэгжилт, үр дүнг нэмэгдүүлэх шаардлагатай бол 70 хувь

3. Зорилт нь шалгуур үзүүлэлт, зорилтот түвшиндээ хүрээгүй, удирдлага, зохион байгуулалт, хариуцлагыг сайжруулж, үйл ажиллагааг эрчимжүүлэх, зорилтод чиглэсэн арга хэмжээг сайжруулах шаардлагатай бол 50 хувь

4. Зорилт, арга хэмжээг илүү сайн тодорхойлох шаардлагатай, шалгуур үзүүлэлт, зорилтот түвшиндээ хүрээгүй, төсөв хөрөнгийг үр дүнтэй зарцуулж

чадаагүй, удирдлага зохион байгуулалт хангалтгүй бол 30 хувь.

4.3. Тэмцээний нийт дүнг 1, 2-р шатны онооны нийлбэрээр гаргана.

4.4. Тэмцээний явц, оролцогч багуудын дүн ил тод, нээлттэйгээр олон нийтийн сүлжээнд тухай бүр нийтлэгдэж байна.

**Тав.** Шагналын төрөл, хэмжээ

5.1. Шалгарсан байгууллагуудад дараах байдлаар шагнана.

5.1.1. Тэргүүн байр—Өргөмжлөл, 10,000,000 төгрөг,

5.1.2. Дэд байр—Өргөмжлөл, 8,000,000 төгрөг;

5.1.3. Гутгаар байр—Өргөмжлөл, 5,000,000 төгрөг;

5.1.4. Гутгаар байр—Өргөмжлөл, 5,000,000 төгрөг;

5.1.5. Гутгаар байр—Өргөмжлөл, 5,000,000 төгрөг;

5.2. Тэмцээний гэрийн даалгаврын оноогоор хамгийн өндөр дүгнэгдсэн 5 багт тус бүр 1,000,000 төгрөгийн мөнгөн урамшуулал, талархал олгоно.

ХЯНАСАН:  
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН  
ГАЗРЫН ДАРГА  Ж.ГАНТУЛГА

БОЛОВСРУУЛСАН:  
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН  
ГАЗРЫН ТӨРИЙН ЗАХИРГААНЫ УДИРДЛАГЫН  
ХЭЛТСИЙН ДАРГА  Ч.БАЯРЦОЛМОН

Хавсралт

Тулгамдаж буй асуудал тодорхойлох маягт

Д/д	Байгууллага, газар хэлтсийн нэр	Ажил үйлчилгээг хэрэгжүүлэхэд тулгамдаж буй асуудал	Шийдэх гарц	Санаачилсан албан хаагчийн нэр
1				
10				

Асуудал-шийдлийн танилцуулга болон гэрийн даалгавар ирүүлэх  
Шүүгчдийн мэдээлэл



№	Байгууллагын нэрс	Асуудал шийдлийн танилцуулга /3.3.6/	Асуудал шийдлийн ажлын гүйцэтгэлийн танилцуулга, нотломжа, /3.4.2/	Байгууллага, сум хариуцсан шүүгчийн мэдээлэл	Гэрийн даалгавар гүйцэтгэсэн ажлын танилцуулга /постер/ 3.3.8/
1.	Стандарт, хэмжил зүйн хэлтэс				
2.	Статистикийн хэлтэс				
3.	Улсын бүртгэлийн хэлтэс				
4.	Хан Хэntий чуулга				
5.	Зооноз өвчин судлалын төв	4 сарын 15-ны дотор	9 сарын 02-ны дотор	Ж.Саруултөгс <a href="mailto:saruultugsj@khenntii.gov.mn">saruultugsj@khenntii.gov.mn</a> 92118975	
6.	Уламжлалт анагаах ухааны төв				
7.	Орон нутгийн өмчийн газар				
8.	БЗӨБЦТС Хэntий салбар				
9.	Татварын хэлтэс				
10.	Санхүүгийн хяналт, дотоод аудитын алба				
11.	Насан туршийн суралцахуйн төв	4 сарын 15-ны дотор	9 сарын 02-ны дотор	Ш.Эрдэнэжаргал <a href="mailto:sh.erdenejargal@gmail.com">sh.erdenejargal@gmail.com</a> /92069906/	5 сарын 01-ний дотор <a href="mailto:otgonzayab17@gmail.com">otgonzayab17@gmail.com</a> 99545475
12.	Авто тээврийн төв				
13.	Хэрлэн голын сав газрын захиргаа				
14.	Ус цаг уур, орчин шинжилгээний төв				
15.	Нэгдсэн эмнэлэг				
16.	Хөдөлмөр, хalamжийн үйлчилгээний газар				
17.	Хүүхэд, гэр бүл хөгжил хамгааллын газар				
18.	Биеийн тамир, спортын газар	4 сарын 15-ны дотор	9 сарын 02-ны дотор	Ж.Цэнджав <a href="mailto:jamaadoritsendjav@gmail.com">jamaadoritsendjav@gmail.com</a> 99018126	
19.	Нийгмийн даатгалын газар				
20.	Эрүүл мэндийн даатгалын хэлтэс				
21.	Эрүүл мэндийн газар				
22.	Боловсрол шинжлэх ухааны газар				
23.	Соёл урлагийн газар				
24.	Хүнс, хөдөө аж ахуйн газар	4 сарын 15-ны дотор	9 сарын 02-ны дотор	Б.Мөнхжаргал <a href="mailto:munkhjargalb@khentii.gov.mn">munkhjargalb@khentii.gov.mn</a> 99040414	
25.	Байгаль орчин, аялал жуулчлалын газар				

26.	Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар				
27.	Мал эмнэлгийн газар				
28.	Политехникийн коллеж				
29.	Нийтийн номын сан				
30.	Музей				
31.	Бэрх				
32.	Батноров				
33.	Баян-Овоо	4 сарын 15- ны дотор	9 сарын 02- ны дотор	Ц.Ганчимэг <a href="mailto:ganchimegts@khentii.gov.mn">ganchimegts@khentii.gov.mn</a> 92114112	
34.	Норовлин				
35.	Дадал				
36.	Баян-Адрага				
37.	Гурванбаян				
38.	Өмнөдэлгэр				
39.	Батширээт	4 сарын 15- ны дотор	9 сарын 02- ны дотор	Ч.Баярцолмон <a href="mailto:bayartsolmonch@khentii.gov.mn">bayartsolmonch@khentii.gov.mn</a> 92114113	
40.	Биндэр				
41.	Хэрлэн				
42.	Баянхутаг				
43.	Галшар				
44.	Бор-Өндөр	4 сарын 15- ны дотор	9 сарын 02- ны дотор	Н.Зоригбаатар <a href="mailto:zorigtbaatarzorigtbaatar04@gmail.com">zorigtbaatarzorigtbaatar04@gmail.com</a> 99086877	
45.	Дархан				
46.	Баянмөнх				
47.	Тахилгат				
48.	Мөрөн				
49.	Жаргалтхаан				
50.	Цэнхэрмандал	4 сарын 15- ны дотор	9 сарын 02- ны дотор	Б.Дарханбаатар <a href="mailto:daak.darkhaa@mail.com">daak.darkhaa@mail.com</a> 99013735	
51.	Дэлгэрхаан				
52.	Хэрлэнбаян-Улаан				
53.	Өлзийт				

-оо-